*Монгол - Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2020 оны 10 -р сарын 12 -ны өдрийн 03/479 албан тоотын Хавсралт*

# БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

| СЭДЭВ | "БОЛОВСРОЛ БА ТЕХНОЛОГИ" | |
|---|---|---|
| ХУРЛЫН ТОВ | Хэзээ: 2020.10.24 09:00-16:30<br>Хаана: Дархан-Уул аймгийн 1-р сургууль | |
| ТОВЧ МЭДЭЭЛЭЛ | Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулиас жил бүр уламжлал болгон явуулдаг Багш нарын VII бага хурал энэ удаа Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгуулагдана. Хурлын гол зорилго нь инженер технологийн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургууль, ЕБС-ийн багш, судлаачдын дунд харилцан туршлага, мэдлэг хуваалцах, байгалийн ухааны болон англи хэлний зайн сургалтад тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх боломж, сургалтын шинэ арга зүйн талаар санал бодлоо солилцоход оршино.<br>"Боловсрол ба технологи" ерөнхий агуулгын хүрээнд ЕБС-уудад "Зайн сургалтын арга зүйг нэвтрүүлэх" талаар онцлон авч хэлэлцэнэ. Уг хурал нь үдээс өмнө нэгдсэн хуралдаан, үдээс хойш англи хэлний багш нарын семинар болон байгалийн ухааны хичээлүүдийн уялдаа холбоог сайжруулах, хүрээлэн буй орчны хичээлийн сургалтын агуулга зэрэг сэдвүүдийг хэлэлцэн математик, физик, хими-хүрээлэн буй орчин гэсэн салбар хуралдаан явагдана. | |
| ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ | **Хамрах хүрээ:** Төвийн бүсийн аймгуудын ЕБС болон инженер технологийн их дээд сургуулийн багш, профессорууд<br>**Хурлын бүтэц:** Илтгэл, хэлэлцүүлэг<br>Илтгэгчид илтгэлийн хураангуйг доорх асуултын дагуу бэлтгэж ирүүлнэ.<br>- Өгүүллийн нэр: "...................................."<br>- Хураангуй: А4-ийн 1 нүүрэнд багтсан байх<br>- Түлхүүр үг: Өгүүлэлд 3-4 түлхүүр үг хэрэглэх ба нэр үг ганц тоон дээр бичнэ.<br>- Ашигласан материал: Цагаан толгойн үсгийн дараалаар<br>- Өгүүллийн төгсгөлд: Илтгэгч болон багийн товч танилцуулга<br>- Хураангуй бэлтгэх зааврыг www.gmit.edu.mn холбоосоор татаж авна. | |
| ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ | Дархан-Уул аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн Газар<br>Дархан-Уул аймгийн 1-р сургууль<br>Е-мэйл: darkhan_uul@itpd.mn<br>Вэб хаяг: www.darkhan.edu.mn | |
| ХОЛБОО БАРИХ | Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, МГТИС-ийн хотхон<br>Утас: **95581138, 99037701** | Цахим хаяг: naturalscience@gmit.edu.mn<br>Цахим хуудас: www.gmit.edu.mn<br>Фэйсбүүк:facebook.com/edu.gmit |
| БҮРТГЭЛ | Илтгэгчдийн тоо хязгаартай тул 2020.10.16-ны дотор naturalscience@gmit.edu.mn хаягаар илтгэлийн хураангуй болон бүртгэлээ илгээнэ үү. | |